

Яагаад Аврагчид Сүм байдаг вэ?

1. Дараах мэдэгдлүүдийг уншаад, яагаад Аврагчид Сүм байдаг шалтгаануудын доогуур зур.



Есүс Христийн сэргээгдсэн Сүм Түүний сургаалын бүрэн дүүрэн байдлыг заахын тулд мөн Бурханы хаант улсад ороход шаардлагатай ёслолуудыг Түүний санваарын эрх мэдлээр гүйцэтгэхээр үүсгэн байгуулагдсан. Сүмд явахаас татгалзаж, зөвхөн хувийн сүнслэг байдалдаа найддаг гишүүд өөрсдийгөө санваарын хүч, адислал, сэргээгдсэн сургаалын бүрэн дүүрэн байдал, сургаалыг хэрэгжүүлэх урам зориг, боломж зэрэг сайн мэдээний хамгийн чухал зүйлсээс тусгаарлагддаг. (Даллин Х.Өүкс, "Сүмд явах хэрэгцээ," *Лиахона*, 2021 оны 11-р сар, 25)



Дэлхий дээр байхдаа Их Эзэний зохион байгуулсан Сүмийн урвалт, задралтаас хойш Тэрээр бошиглогч Иосеф Смитээр дамжуулан Сүмийг дахин зохион байгуулжээ. Есүс Христийн сайн мэдээг номлох, авралын ёслолуудыг гүйцэтгэх, өөрөөр хэлбэл, хүмүүсийг Христэд авчрах гэсэн эртний зорилго нь хэвээр үлдсэн юм. Эдүгээ, Аврагчийн ач ивээлийн талаар мөнх бус амьдралдаа зах зухаас нь сонссон эсвэл огт олж мэдэх боломжгүй байсан нас барагсдын сүнснүүд энэ сэргээгдсэн Сүмээр дамжуулан гэтэлгэлийн амлалтаас хүртэх боломжтой болсон билээ. (Д.Тодд Кристоффэрсон, "Сүм яагаад хэрэгтэй вэ?" *2015 оны 10-р сарын Ерөнхий чуулган*, 104)

сарын Ерөнхий чуулган, 104)

Яагаад Аврагч дэлхий дээр Сүм байгуулсан тухай эдгээр захиаснаас сурсан зүйлээ товч дүгнэн бич.

2. 1830 оны 4-р сард Сүм зохион байгуулагдах үед Мормоны Ном анх удаа хэвлэгдэн гарчээ. Сургаал ба Гэрээ 20:9–36 дээр Их Эзэн Мормоны Номд заагддаг маш олон үнэнийг онцолсон.

Дараах багц шүлгийг судлаад, Аврагч Өөрийнхөө болон сургаалынхаа талаар заасан чухал үнэнүүдийг олж мэд. Чухал мэдээллийг олж мэдэхэд туслах эдгээр судартай холбоотой зүүлт тайлбарыг ашиглахыг бод.

Сургаал ба Гэрээ 20:8–15 (Мормоны Ном ба энэ номын Сэргээлтэд гүйцэтгэх үүрэг)

Сургаал ба Гэрээ 20:17–25 (Авралын төлөвлөгөө)

Судалсан үнэнүүдээс хоёр эсвэл түүнээс олныг сонго. Сүм үндэслэгдэн байгуулагдах үед эдгээр үнэнийг онцлох нь яагаад чухал гэдгийг бодоод, бичиж тэмдэглээрэй.